



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
Аудитор:		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn
		Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

᠑᠗᠕᠕ ᠒᠑.᠒᠘ № ᠒᠖/᠑᠖᠑

танай _____-ны № _____-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.АНХБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Замын-Үүд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 17 төсвийн шууд захирагч, 2 тусгай сангийн нийт 19 санхүүгийн тайлангаас 10 байгууллагыг түүвэр аудитад хамруулж, аудитаар 6 зөрчилгүй, 2 хязгаарлалттай (Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Замын-Үүд сумын Соёл, спортын ордон), 1 татгалзсан (Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар) санал дүгнэлтийг өглөө.

Мөн Замын-Үүд сумын Захирагчийн ажлын алба 1.4 сая, Замын-Үүд сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 12.9 сая, Замын-Үүд сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг 2.6 сая, Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг 1.1 сая, Замын-Үүд сумын Орон нутгийн хөгжлийн сан 69.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн.

Тус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд материаллаг байдлын түвшинг 144.2 сая төгрөгөөр тогтоосон. Сумын Засаг даргын багцад багтах төсвийн шууд захирагчдын тайланд илэрсэн нийт зөрчил нь 769.1 сая төгрөг буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 5 дахин давсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

010020132

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,000.8	3,993.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	25,303.4	26,408.9
	Нийт хөрөнгийн дүн	29,304.2	30,402.0
	Нийт өр төлбөрийн дүн	638.4	162.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	28,665.8	30,240.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	29,304.2	30,402.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	20,213.4	19,770.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	16,894.3	17,984.8
	Үйл ажиллагааны үр дүн	3,319.1	1,785.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	22.3	149.2
	Үйл ажиллагааны нийт үр дүн	3,296.8	1,636.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	16,381.4	16,759.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	15,480.5	14,305.9
	Үйл ажиллагааны ЦМГ	900.9	2,453.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	814.3	2,248.4
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	86.6	204.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	246.7	333.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	333.3	538.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	25,368.9	28,583.7
	Тайлант оны үр дүн	3,296.8	1,636.6
	Эцсийн үлдэгдэл	28,665.7	30,239.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	11,287.9	13,542.6
	Урсгал зардал	10,648.3	11,701.6
	Хөрөнгийн зардал	639.6	1,841.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	11,325.7	13,814.9
	Улсын төсвөөс санхүүжих	7,843.7	8,996.3
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,404.4	4,562.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	77.6	255.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Замын-Үүд сум үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Тогтвортой хөгжил эрүүл, тохилго бүс нутаг байх” гэж тодорхойлсон байна.

Тус сум нь 2021 оныг “Эрүүл мэндийг дэмжих” жил болгон зарлаж, үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон байна.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна. Үүнд:

- Нутаг дэвсгэрт төрийн бүх шатны бодлого зорилгыг зохион байгуулан, “Бид хамтдаа” мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

- Нутаг дэвсгэрийн орон нутаг дахь байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоог хангах, тэдгээр байгууллагуудыг бодлогын удирдамж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого боловсруулах;
- Орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх;
- Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг сурталчлан таниулах;
- Иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалж, хүн амын нийгэм соёлын үйлчилгээ, дэд бүтэц, хот байгуулалтын төсөв санхүүгийн чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;
- Төрийн удирдлагыг орон нутагт хэрэгжүүлэх;
- Төрийн албан хаагчдыг авлигал, хээл хахуульд авталгүй үнэнч шударга, төрийн албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулах;
- Хууль, тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл оруулсан, хугацаа хоцроосон 16 мэдээлэл байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засаг даргын Тамгын газар нь доорх зөрчлүүдийг гаргасан. Үүнд:

- Тайлант оны эцэст арилжааны банкин дахь түр харилцах дансанд 41.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг бэлэн мөнгөөр гарган авсан.
- Сумын ЭМТ-өөс авах авлага 23.0 сая төгрөгийг төрийн сангийн гүйлгээ хаагдсан гэх шалтгаанаар арилжааны банкин дахь жижиг мөнгөн сангийн дансаар дамжуулан бэлнээр гарган авч төрийн сангийн харилцах дансанд тушаагаагүй.
- Чандмань Бадрал ХХК татан буугдсантай холбоотой 210.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн харилцахын дансанд хүлээн авсан.
- Иргэн, аж ахуйн нэгжээс 113.7 сая төгрөгийг бэлэн мөнгө, 77.2 сая төгрөгийн бараа материалыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шууд хүлээн авч, зарцуулсан.
- Ахмадын хорооны өрөөг тохижуулах тоног төхөөрөмжийн зардалд орон нутгийн нөөц хөрөнгөөс 6.0 сая төгрөгийг шилжүүлэн бэлнээр гарган авсан бөгөөд тоног төхөөрөмжийг бүрэн хүлээж аваагүй гэх шалтгаанаар мөнгийг шилжүүлээгүй.
- Тус сумын төрийн сангийн холбогдох мэргэжилтнүүд гүйлгээг алдаатай хийж төсвийн байгууллагуудын гүйлгээг хувийн компани руу бөөнд нь шилжүүлэн зарлагын гүйлгээ хаасан шалтгаанаар эргүүлэн төвлөрүүлэлгүй тухайн компанийн данснаас шууд холбогдох зардлыг шилжүүлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн нь санхүүгийн хяналт муу байгааг харуулж байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 17 төсвийн байгууллага, 2 тусгайн сан, 4 ахмадын сан, 1 хөрөнгө оруулалтын дансны нийт 24 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллагад дүгнэлт гаргаж, 8 байгууллага, 2 сан түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 6 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт, 2 байгууллагад “хязгаарлалттай” дүгнэлт, 1 “татгалзсан” дүгнэлт өгсөн байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 3 алдаа, зөрчил илрүүлснээс 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, ОНХС-ийн 1-12 сарын төлөвлөгөө гүйцэтгэлийг мэдээлээгүй, 315.4 сая төгрөгийн 14 захирамжийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.3.9 *“орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл”*, 6.4.8 *“бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

2. Төсвийн орлого 6,724.7 сая төгрөгийн төлөвлөгөөнөөс 3,998.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 59 хувьтай биелсэн байна. Орлого 2,725.9 сая төгрөгөөр тасарсан байна. Мөн өмнөх онд орлого төлөвлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 *“шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”*, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 *“хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа, зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,826.5 сая төгрөгийн 95 алдаа, зөрчил илрүүлснээс 5,057.4 сая төгрөгийн 32 алдааг аудитын явцад залруулж, 646.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 32 албан шаардлага хүргүүлж, 81.1 сая төгрөгийн 9 төлбөрийн акт тогтоож, 42.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 22 зөвлөмжийг хүргүүлсэн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Сумын харьяа байгууллагууд НББ хөтлөлт, тайлагналтын алдаа зөрчлийг давтан гаргасан, байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, алдаа зөрчил өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.3, 1.1.10 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								Дүгнэлтийн хэлбэр
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	ИТХ	9	47.2	1	27.1	2	2.8	4	13.2	2	4.1	хязгаарлалттай
2	ЗДТГ	16	871.8	3	213.7	2	6.2	8	619.3	3	32.6	татгалзсан
3	ЗАА	7	7.6	2	6.2	1	1.4	4	-	-	-	зөрчилгүй
4	ЕБС 1	7	121.6	5	121.6	-	-	2	-	-	-	зөрчилгүй
5	ЕБС 2	4	36.0	2	36	-	-	1	-	1	-	зөрчилгүй
6	ЕБС 3	3	18.6	2	18.6	-	-	1	-	-	-	зөрчилгүй
7	Үлэмж тэнгэр сургууль	1	-	-	-	-	-	-	-	1	-	түүвэр
8	Цэцэрлэг 1	5	5.1	2	5.1	-	-	1	-	2	-	түүвэр
9	Цэцэрлэг 2	4	14.0	2	1.1	-	-	1	12.9	1	-	түүвэр
10	Цэцэрлэг 3	4	2.6	-	-	1	0.1	1	0.4	2	2.1	түүвэр
11	Цэцэрлэг 4	5	4.8	2	3.9	1	0.9	1	-	1	-	түүвэр

12	Цэцэрлэг 5	3	1.1	-	-	-	-		-	3	1.1	түүвэр
13	Цэцэрлэг 6	4	7.7	3	7.7	-	-	1	-	-	-	түүвэр
14	Цэцэрлэг 7	3	1.3	2	1.1	-	-	1	0.2	-	-	зөрчилгүй
15	Болор- Эрдэнэ цэцэрлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	түүвэр
16	Борхойн наран ӨЭМТ	3	-	-	-	-	-	1	-	2	-	зөрчилгүй
17	Соёл спортын төв	8	2.1	-	-	-	-	5	-	3	2.1	хязгаарлалттай
18	ОНХС	6	3278.5	3	3208.8	2	69.7	-	-	1	-	түүвэр
19	СХС	3	1406.5	3	1406.5	-	-	-	-	-	-	түүвэр
20	ТТЗ	3	-	-	-	-	-	2	-	1	-	хязгаарлалттай
	НИЙТ	98	5826.5	32	5057.4	9	81.1	34	646.0	23	42.0	-